

## ӨМНӨХ ҮГ

“Монголын хүн амын Сэтгүүл” нь хүн ам зүй болон хүн ам, хөгжлийн асуудлаар Монгол Улсад хийгдсэн эрдэмтэд, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүд, мэргэжлийн тооцоо, шинжилгээний онол, техник, арга зүйн сургалтууд, асуудал хөндсөн шүүмж, үзэл бодлыг хөгжлийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, мэргэжилтнүүд, олон улсын донор байгууллагууд, судлаачид, оюутнууд болон сонирхсон бусад олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор бэлтгэгддэг.

Сэтгүүл нь хянан магадалгаа хийгддэг, монгол болон англи хэлээр холимог байдлаар хэвлэгддэг Монгол Улсын Их Сургуулийн эрдмийн бичиг юм. Монголын хүн амын сэтгүүлийг 1996 оноос эхлэн жил бүр тасралтгүй бэлтгэн, хэвлэмэл болон онлайн хэлбэрээр Монгол Улсын Их Сургуулийн сэтгүүлийн нэгдсэн сан болох <https://journal.num.edu.mn/MJP/index> цахим хуудаст байрлуулж ирсэн.

Сэтгүүлд нийтлэгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, сэтгүүлийн дараагийн дугаарт өөрийн бүтээлээ ирүүлнэ гэдэгт бид итгэж байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаач болон сэтгүүлийн энэ дугаарыг бэлтгэн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монгол Улсын Их Сургуульд сэтгүүлийн редакцын зөвлөл гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тэлэх болтугай.

## РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ